



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ИТХ-ын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (705) 2-27-34

Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2022.02.25 № 16/2025

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
У.ОТГОНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дэлгэрэх сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн оны эхний авлага дансны үлдэгдэлд тусгагдсан 0.5 сая төгрөг, өглөгийн 0.2 сая төгрөг, нийт 0.7 сая төгрөгийн авлага, өглөгийг эзэн холбогдогч тодорхойгүй шалтгаанаар барагдуулаагүй, зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж 1.2 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, хөрөнгө зарцуулахдаа тушаал шийдвэрт тусгаснаас бусад зардалд 1.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зардлын эдийн засгийн ангилал"-ыг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1, үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн нийт дүн 3.6 сая төгрөг болж, тогтоосон материаллаг байдлын түвшин 0.2 сая төгрөгөөс давсан байна.

010020020

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>1,808,219.00</u>	<u>2,169,639.00</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>6,203,713.83</u>	<u>7,556,755.90</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>8,011,932.83</u>	<u>9,726,394.90</u>
	Нийт өр төлбөрийн дүн	<u>491,720.52</u>	<u>276,052.87</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>7,520,212.31</u>	<u>9,450,342.03</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>8,011,932.83</u>	<u>9,726,394.90</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	64,782,300.00	62,501,685.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	61,644,452.24	60,571,555.28
	Үйл ажиллагааны үр дүн	<u>3,137,847.76</u>	<u>1,930,129.72</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>3,137,847.76</u>	<u>1,930,129.72</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,520,212.31	7,520,212.31
	Тайлант оны үр дүн		1,930,129.72
	Эцсийн үлдэгдэл	7,520,212.31	9,450,342.03
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>64,782,300.00</u>	<u>62,501,685.00</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>60,479,800.00</u>	<u>60,201,685.00</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>4,302,500.00</u>	<u>2,300,000.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(1,940,000.00)</u>	<u>(2,300,000.00)</u>
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2,362,500.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		60,207,685.00
	Урсгал зардал		60,207,685.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		60,207,685.00
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		60,207,685.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх.

Эрхэм зорилго: Албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, өсөж дэвших, боломжийг хангах, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг үзүүлэх.

Алсын хараа: Нутгийн захиргааны тэргүүлэгч байгууллага болох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын ажил гүйлгээ гараагүй, хөрөнгө зарцуулах тухай 10 тушаалыг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 5.8 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлснээс, 2.2 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, 1.7 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа:

1. НИК ХХК-д тээвэр шатахууны зардлаас 1.3 сая төгрөг, БГАҮТХ-ийн зардлаас 7.8 сая төгрөг, нийт 2.1 сая төгрөгийг шилжүүлснийг нярав шатахууны тайланд 1.8 сая төгрөгийн орлого авч, зөрүү 0.3 сая төгрөгийг шууд зардалд бүртгэснийг авлагын дансанд тусгаж залруулав.

2. Үндсэн хөрөнгийн номын фондын дансанд 0.06 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг ном бүртгэснийг бичиг хэргийн материалын дансанд шилжүүлэн бүртгүүлж залруулав.

3. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 1.8 сая төгрөгөөр дутуу тооцсоныг залруулав.

Албан шаардлага:

1. Дэлгэрэх сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн оны эхний авлага дансны үлдэгдэлд тусгагдсан 0.5 сая төгрөг, өглөгийн 0.2 сая төгрөг, нийт 0.7 сая төгрөгийн авлага, өглөгийг эзэн холбогдогч тодорхойгүй шалтгаанаар барагдуулаагүй байна.

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж, өмнө оны эзэн холбогдогч тодорхой бус авлага, өглөгийн үлдэгдлийг тодорхой болгож, шийдвэрлэх тухай албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд 1.2 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэмэлтийн харилцах дансанд аймгийн ИТХ-аас тодорхой үйл ажиллагааны зардлын дэмжлэг нийт 2.2 сая төгрөг олгож, сумын ИТХ-ын даргын 2021.12.12-ны өдрийн А/10 захирамжаар 1.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авахаар шийдвэр гаргаж, 450.0 мянган төгрөгийн материал, ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг сургалт мэдээллээр хангахад 1.2 сая төгрөгийг зарцуулахаар тусгаж, шатахуун, бичиг хэргийн материал худалдан авсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дэлгэрэх сумын ИТХурал	1	1	-	-	-	1	-	-
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дэлгэрэх ИТХурал	7	5.8	3	2.2	0	0	2	1.9	1	1.7
НИЙТ		7	5.8	3	2.2	0	0	2	1.9	1	1.7